



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар A/84

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дах заалт, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын 2020 онд өөрийн хөрөнгөөр санхүүжих зохиогчийн эрхийн программ хөгжүүлэх, архивын баримтын цахимжуулалтын ажлыг зохион байгуулах гүйцэтгэгчийг Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

- Захиргаа удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг

Нарийн бичгийн дарга:

- Эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн
С.Цоггэрэл

Гишүүд:

- Хууль зүй дотоод хэргийн яамны, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Д.Даваажаргал
- Мэргэжилтэн /шинжээч/ Г.Ууганцэцэг
- Худалдан авах ажиллагааны хөтөч ТББ-ын
Нягтлан бодогч Б.Анударь

2. Тендер сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга С.Ганзоригт даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР

000445